



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМ
“ФРИЕНДШИП РЕСУРСИС” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
“ДАЛАНГИЙН НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР ОЛБОРЛОХ”
ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТАЙЛАН**

*/Тусгай зөвшөөрөл: MV-014492/
/ААН-н регистрийн дугаар: 5877288/*

**ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: “ФРИЕНДШИП РЕСУРСИС” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

Б.МӨНХТУЯА

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Н.ЭРДЭНЭБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНХ-ЭРДЭНЭ

ДОРНОГОВЬ, ДАЛАНЖАРГАЛАН СУМ 2024 ОН

Гарчиг

1.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.2.	Төслийн товч танилцуулга.....	4
1.3.	Уурхайн хүчин чадал	4
1.4.	Уурхайн ажиллах горим	4
1.5.	Уурхайн ажиллах хүчин.....	4
1.6.	Уулын ажлын төлөвлөгөө.....	4
1.7.	Уурхайн тээвэр.....	5
2.	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	8
3.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	10
4.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
4.1.	Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө	11
4.2.	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө	12
4.3.	Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн хамгаалал хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	13
4.4.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	14
4.5.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	14
4.6.	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	15
4.7.	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	15
4.8.	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	15
4.9.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
4.10.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	18
4.11.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	20
4.12.	БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Төслийн талбайн координат цэг	3
Хүснэгт 2.	2024 онд ажиллах хоног	4
Хүснэгт 3.	Уулын ажлын төлөвлөгөө	5
Хүснэгт 4.	Үйлдвэрлэлийн нөөц	5
Хүснэгт 5.	Уулын ажлын календарь төлөвлөгөө	6
Хүснэгт 6.	Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүн	8
Хүснэгт 7.	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар	8
Хүснэгт 8.	Усны нөөцөд үзүүлэх нөлөөллийн тайлбар	8
Хүснэгт 9.	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар	8
Хүснэгт 10.	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар	8
Хүснэгт 11.	Шимт хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар	9
Хүснэгт 12.	Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл	9
Хүснэгт 13.	Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө	11
Хүснэгт 14.	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө	12
Хүснэгт 15.	Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн хамгаалал хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	13
Хүснэгт 16.	Нөхөн сэргээлтийн зардал	14
Хүснэгт 17.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	14
Хүснэгт 18.	Төслийн явцад хэрэгжүүлэх түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	15
Хүснэгт 19.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт 20.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 21.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	19
Хүснэгт 22.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	20

Хүснэгт 23. БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах хуваарь	21
Хүснэгт 24. БОМТ-ний нийт зардал	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил	3
Зураг 2. Уулын ажил	7

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч:

“Фриендшип ресурсис” ХХК

УБД: 0611007034, РД: 5877288

Төслийн нэр:

“Далангийн нүүрсний ордыг ил аргаар олборлох” төсөл

Төслийн зорилго:

Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлж нүүрс

олборлох


Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-014492

Төслийн талбайн байршил: MV-014492 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Далан хэмээх газар.

Улаанбаатар УБ хотоос зүүн урагш 270 км-т, Даланжаргалан сумаас хойд зүг 28 км-т тус тус байрлана.

Хүснэгт 1. Төслийн талбайн координат цэг

№	Уртраг	Өргөрөг
1	108° 57' 51.63" E	46° 07' 11.66" N
2	108° 57' 51.63" E	46° 07' 31.66" N
3	108° 56' 41.64" E	46° 07' 31.65" N
4	108° 56' 41.64" E	46° 07' 11.66" N



Зураг 1. Төслийн талбайн байршил

1.2. Төслийн товч танилцуулга

Тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны нэгжийн хуваариар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, төмөр замын 25-р зөрлөг болон Улаанбаатар-Сайншандыг холбосон автозамаас 24 км, Даланжаргалан сумаас баруун хойш 28 км зайд байршина.

Далангийн талбай нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтоогогийн нүүрсний ордын нэг хэсэг болох бөгөөд байршлын хувьд “Монголын Алт” ХХК-ийн ашиглаж байсан Элдэвийн нүүрсний уурхайгаас баруун тийш 2-4 км-ийн зайд Баруундалангийн зүүн энгэрт байрладаг.

1.3. Уурхайн хүчин чадал

MV-014492 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Далан нүүрсний ордыг “Фриендшип ресурс” ХХК нь ил аргаар 7 жилийн хугацаанд олборлохоор төлөвлөсөн.

MV-014492 тоот талбайд хамаарах нийт бодитой (B) нөөц 7,331.34 мян.тн, нийт баялаг (P) нөөц 357.73 мян.тн, тус талбайн хэмжээнд бодитой болон баялаг нийт нөөц 7,689.07 мян.тн ноогдож байна. Уурхайн суурьлагдсан хүчин чадлын хэмжээ 600.0 мян.тн юм. Урьд жилүүдэд уурхайн бүрэн хүчин чдалаа эзэмшиж байсан удаагүй. Дунжаар 30-50%-ийн гүйцэтгэ

1.4. Уурхайн ажиллах горим

Хүйтний хүндрэлийг давах үүднээс 2024 оны 01-р сарын 01-15 хүртэл уурхай зогссон түүнээс хойш ажиллаж эхэлсэн. Мөн уурхай 7-р сард 10-20 хоногийн уртын амралт, ирэх оны сүүлээр мөн 10 хоногийн амралтын төлөвлөгөөтэй байна. Уурхайн цэвэр ажлын хоног 240 хоног ажиллахаар тусгалаа.

Хүснэгт 2. 2024 онд ажиллах хоног

Жилд ажиллах сарууд	Нийт
Хуанлийн өдрүүд	364
Баяр ёслол	10
Засвар үйлчилгээ, цаг агаарын хүндрэл	24
Уурхай ажиллахгүй хуваарьт хоног	60
Ажиллах өдөр	270
Тооцоолоогүй саатал	30
Уурагийн цэвэр ажлын хоног	240

1.5. Уурхайн ажиллах хүчин

Уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг уурхайн дарга, ерөнхий инженер, ерөнхий геологич, уулын мастерууд, хөдөлмөр хамгаалал сургалтын инженер, ашиглалтын геологи нар удирдан явуулна.

Уурхай 2023 оны төгсгөлд 60-70 ажилтантай байсан бөгөөд хүчин чадлаа бүрэн дүүрэн ашиглах зорилтын хүрээнд 2024 онд ажиллах хүчний тоог нэмэгдүүлэн ажиллахад уурхайн хэмжээнд нийтдээ 122 хүн шууд ажлын байр бий болохоор байна.

1.6. Уулын ажлын төлөвлөгөө

2021-2022 онуудад уурхай зогсонги байдалтай байсан бол 2023 онд уурхайн бүтэн жилийн хугацаанд хэвийн ажиллаа. 2023 оны 2-р улирлын сүүлээс 3-р улирал дуустал нүүрс зах зээлийн буурч эрэлт муутай байсан боловч харилцагч нар нүүрсээ нөөцөлсөн тул тус хүндрэлийг даван гарсан. 2024 онд уурхай ТЭЗҮ-ийн хүчин чадал болох 600 мян.тн хэмжээнд бодитой хүрэх бололцоотой гэж үзэж байна.

Далангийн уурхайн төлөвлөгөөгөөр 2024 оны уулын ажлын хэмжээ уулын цулаар 2,978.8 мян.м³ байна. Үүнээс ил уурхайн уулын ажлын хэмжээ нь олборлолтонд өртөх нөөц нь 632.65 мян.тн, хөрс хуулалт 2,492.2 мян.м³ байна. Хөрс хуулалтын дундаж коэффициент нь 3.94 м³/тн байхаар байна. Уурхайн тэлэлтийн ажлын шимт хөрс хуулалт 3.53 мян.м³ болно. Дээрх уулын цул дээр гадаад овоолгын тэлэлтийн шимт хөрс хуулалт 1.53 мян.м³ нэмэгдэнэ.

Хүснэгт 3. Уулын ажлын төлөвлөгөө

№	Утга	Нэгж	Давхраасууд			Нийт
			1	2	3	
1	Уулын цул	м ³	1,266,574.4	1,220,811.1	491,460.0	2,978,845.5
2	Нийт хөрсний хэмжээ	м ³	1,093,882.2	987,486.1	410,820.0	2,492,188.3
3	Хөрсний цул	м ³	969,600.0	878,733.0	383,940.0	2,232,273.0
	Тэсэлгээтэй	м ³	321,000.0	816,600.0	331,800.0	1,469,400.0
	Тэсэлгээгүй	м ³	648,600.0	62,133.0	52,140.0	762,873.0
4	Давхраасын уулын цул	м ³	124,282.2	108,753.1	26,880.0	259,915.3
5	Нүүрсний үеийн бохирдол	м ³	296,974.4	342,078.1	107,520.0	746,572.5
6	Нүүрсний хэмжээ	м ³	172,692.2	233,325.0	80,640.0	486,657.2
7	Нягт	тн/м ³	1.3	1.3	1.30	1.3
8	Нүүрсний хэмжээ	тн	224,499.9	303,322.5	104,832.00	632,654.4
9	Кхх	м ³ /тн	4.87	3.26	3.92	3.94

Үйлдвэрлэлийн нөөц: Үйлдвэрлэлийн нөөц нь хаягдлыг хасч, бохирдлыг нэмж тооцсоноор тодорхойлогдоно. Уурхайн 2024 оны үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ 600.01 мян.тн нүүрс байна.

Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн нөөц

№	Утга	Нэгж	Давхраасууд			Нийт
			1	2	3	
1	Олборлолтын нөөц	Тн	224,499.9	303,322.5	104,832.0	632,654.4
2	Хаягдлын хэмжээ	Тн	18,745.7	28,542.6	7,086.6	54,375.0
3	Бохирдлын хэмжээ	Тн	7,498.3	11,404.9	2,830.5	21,733.7
4	Үйлдвэрлэлийн нөөц	тн	213,252.4	286,184.7	100,575.8	600,013.02
7	Хаягдлын хэмжээ	%	8.35%	9.41%	6.76%	8.59%
8	Бохирдлын хэмжээ	%	3.34%	3.76%	2.70%	3.44%
9	Хөрс хуулалтын хэмжээ	м ³	1,102,534.1	1,000,669.0	414,094.0	2,517,297.0
10	Тэсэлгээтэй хөрс	м ³	321,000.0	816,600.0	331,800.0	1,469,400.0
11	Тэсэлгээгүй хөрс	м ³	781,534.1	184,069.0	82,294.0	1,047,897.0
12	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /тн	5.17	3.50	4.12	4.20

Хөрс хуулалтын дундаж коэффициент 4.2 м³/тн болно.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө: Уурхайн үйл ажиллагаанд өртөх газарт шимт хөрс хуулалтын ажлыг урьдчилан гүйцэтгэх бөгөөд овоолго нөхөн сэргээлт, уурхайн хаалт хэлбэршүүлэлтийн ажилд хэрэглэгдэх тул уурхайн талбайгаас гаргаж ил уурхайн зүүн урд талд үргэлжлүүлэн овоолго үүсгэн хуримтлуулна.


Хөрсний овоолгыг уурхайн ашиглагдсан орон зайд үргэлжлүүлэн, шимт хөрсийг уурхайн зүүн урд талын ашиглалтгүй үлдэх талбайд байршуулж байна. Хөрсний овоолго нь уурхайн фронтын нийт уртын дагуу урдаас хойш чиглэлд ахилт хийх байдлаар 3-н түвшингээр зэрэг хийгдэхээр байна. Гадаад овоолгод нөхөн сэргээлтийн бэлтгэл болгож овоолгын хойд болон баруун хойд талдаа бага хэмжээний тэлэлт хийнэ.

2024 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 1-р сарын 15-ноос уурхайн ажил эхлэх бөгөөд 1-р улиралд 140 мян.тн, 2 болон 4-р улиралд тус бүр 160, 3-р улиралд 140 орчим мян.тн нүүрс олборлон борлуулахаар төлөвлөж байна. Хөрс хуулалтын ажлыг 1-р улиралд багаар бусад улиралд олборлолтын хүчин чадалд нийцүүлэн хийнэ.

Уурхайн олборлолт, хөрс хуулалтын ажлын календарь төлөвлөгөөг доор үзүүлэв.

Хүснэгт 5. Уулын ажлын календарь төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Нэгж	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Нийт
1	Олборлолтын хэмжээ	мян.м ³	107.7	123.1	107.7	123.1	461.55
2	Ашигт малтмалын нягт	кг/м ³	1.3	1.3	1.3	1.3	1.30
3	Олборлолтын хэмжээ	мян.тн	140.0	160.0	140.0	160.0	600.01
4	Хөрс хуулалтын хэмжээ	мян.м ³	280.00	748.11	649.54	839.65	2,517.29
5	Шимт хөрс хуулалтын хэмжээ	мян.м ³	-	2.3	2.7	-	5.06
6	Нийт уулын цул	мян.м ³	387.7	873.5	759.9	962.7	2983.90
7	Хөрс хуулалтын дундаж коэффициент	тн/м ³	2.00	4.69	4.66	5.25	4.20
Овоолгын эзэлхүүн							
1	Гадаад овоолгын хэмжээ	мян.м ³	0.00	0.00	153.00	0.00	153.00
	Сийрэгжилтын хэмжээ		1.18	1.18	1.18	1.18	1.18
2	Дотоод овоолгын хэмжээ	мян.м ³	330.40	882.76	613.45	990.79	2817.41
	Сийрэгжилтын хэмжээ		1.18	1.18	1.18	1.18	1.18
3	Шимт хөрсний овоолгын хэмжээ	мян.м ³	0.00	2.81	3.26	0.00	6.07
	Сийрэгжилтын хэмжээ		1.20	1.20	1.20	1.20	1.20
Уулын ажлын хэмжээ өсөх нийлбэрээр (уулын цулаар)							
1	Нүүрс олборлолт	мян.тн	140.00	300.00	440.00	600.01	600.01
2	Хөрс хуулалт	мян.м ³	280.00	1028.11	1677.64	2517.30	2517.30
3	Шимт хөрс хуулалт	мян.м ³	0.00	2.34	5.06	5.06	5.06



Зураг 2. Уулын ажил

1.7. Уурхайн тээвэр

Уурхайгаас олборлосон нүүрсийг хэрэглэгчдэд хүргэхийн тулд нүүрс тээвэрлэлтийг 50 тн-оос ихгүй даацын автомашинаар гүйцэтгэдэг. Хамгийн ойр орших төмөр замын өртөө бол “Олон овоо” нэртэй өртөө уурхайн талбайгаас 24 км зайд байна. “Элдэв”-ийн уурхайн тавьсан нүүрс тээврийн сайжруулсан шороон зам өртөөнд хүрэх бөгөөд тус замаар нүүрс тээвэрлэлтийг хийнэ. Гадаад тээврийн автосамосвал хоногт 6-8 удаа тээвэр хийх боломжтой.

Хоногт дунжаар 25 рэйс хийх шаардлагатай бөгөөд үүнийг 4-5 ширхэг нүүрс тээврийн автосамосвалаар хангах бололцоотой. Гадаад тээврийг туслан гүйцэтгэгчээр хийлгэнэ.

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төсөл хэрэгжих үеийн сөрөг нөлөөллийн үнэлгээгээр гол сөрөг нөлөөлөл нь шинээр олборлолт явуулах үед хөрсөн бүрхэвч ба ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл байна.

Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүнг дараах хүснэгт үзүүлэв.

Хүснэгт 6. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүнг

№	Нөлөөлөл	Үнэлгээ							
		Эерэг				Сөрөг			
		Бүгд	Их	Бага	Дунд	Бүгд	Их	Бага	Дунд
1	Газрын гадарга					4	1		3
3	Агаарын чанар					4		2	2
4	Усан орчин					4		4	
5	Хөрсөн бүрхэвч					5	1		4
6	Ургамалан нөмрөг					6	3		3
7	Амьтны аймаг					3			3
8	Нийгэм, эдийн засаг	4	1		2				1

Хүснэгт 7. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт	Хөрс хуулалтыг экскаватороор хуулах бөгөөд түүний дизель хөдөлгүүрээс ялгарах CO, CO2, NOx, SO4 болон бусад бохирдуулагч бодисын агаар дахь дисперсээр агаарын чанарт өөрчлөлт орж болно. Мөн салхитай хуурай үед хөрс хуулалтын ажил явуулах үед агаарт тоосонцор дэгдэнэ.
2	Өрөмдлөг, тэсэлгээ	Өрөмдлөгийн ажил гүйцэтгэх өрмийн автомашины хөдөлгүүрээс агаарт бохирдуулагч бодис ялгарна. Тэсэлгээний ажлын үед агаар их хэмжээний тоосжилт үүснэ.
3	Ухаж ачих	Ухаж ачих үед агаарт тоосонцор дэгдэх болон автосамовалийн хөдөлгүүрээс агаарт бохирдуулагч бодис ялгарна.
4	Тээвэрлэх	Тээвэрлэлтийн автомашины дугуйны хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх мөн автосамовалийн хөдөлгүүрээс агаарт бохирдуулагч бодис ялгарна.
5	Овоолох	Хуурай салхи ихтэй үед агаарт тоосонцор дэгдэнэ.

Хүснэгт 8. Усны нөөцөд үзүүлэх нөлөөллийн тайлбар

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт	Нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй
2	Өрөмдлөг, тэсэлгээ	Нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй
3	Ухаж ачих	Суурь хөрс хуулалтын үед шүүрэлт явагдсан тохиолдолд нөөцөд нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.
4	Тээвэрлэх	Нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй
5	Овоолох	Нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй

Хүснэгт 9. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт	Хөрс хуулалт нь ургамлан бүрхэвчид шууд нөлөөлөл үзүүлнэ.
2	Өрөмдлөг, тэсэлгээ	Өрөмдлөг, тэсэлгээний ажил нь ургамлан бүрхэвчид шууд нөлөөлөл үзүүлнэ.
3	Ухаж ачих	Ухаж ачих ажлаас үүсэх тоосонцорын тархалт нь ургамлан бүрхэвчид дам нөлөөлөл үзүүлнэ.
4	Тээвэрлэх	Тээвэрлэлт нь шууд болон дам нөлөөлөл үзүүлж болзошгүй.
5	Овоолох	Шимт хөрсний овоолгод ургамлан бүрхэвч дарагдана.

Хүснэгт 10. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт	Хуулагдаж буй шимт хөрсөнд амьдарч байсан хөрсний бичил организ, нүхэнд амьдардаг амьтдын үүр эвдрэх, шимт хөрс хуулалтын үеийн бульдозерын дуу чимээ, газар чичирхийлэл,

		үүсэх тоосжилт зэрэг нь амьтдын шилжилт хөдөлгөөн, амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
2	Өрөмдлөг, тэсэлгээ	Сөрөг нөлөөлөл нь дээрхтэй адил. Тэсэлгээний үеийн огцом гарах дуу чимээнээс амьтад дайжих, идэш тэжээл нь багасах зэрэг сөрөг нөлөөлөл үүснэ.
3	Ухаж ачих	Хуулагдаж буй хөрсөнд амьдарч байсан хөрсний бичил организ, нүхэнд амьдардаг амьтдын үүр эвдрэх, ухаж ачих үеийн бульдозерын дуу чимээ, газар чичирхийлэл, үүсэх тоосжилт зэрэг нь амьтдын шилжилт хөдөлгөөн, амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
4	Тээвэрлэх	Тээвэрлэлтийн үеийн автомашины дуу чимээ, үүсэх тоосжилт, хорт хий зэргээс амьтны аймагт сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Мөн амьтад тээврийн хэрэгсэлд дайрагдах, үүр эвдэгдэх зэрэг аюултай.
5	Овоолох	Овоолго үүсгэх үед амьтдын үүр, идэш тэжээлтэй орчин дарагдах, дуу чимээнээс үүдэлтэй амьтад дайжих зэрэг сөрөг нөлөөлөл үүснэ.

Хүснэгт 11. Шимт хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт	0.2-0.3м-с ихгүй зузаантай шимт хөрс хуулагдана. Хөрс тээвэрлэлтийн үед шимт хөрс нөлөөлөлд өртөнө.
2	Шимт хөрс хадгалах	Шимт хөрс хадгалах үед тухайн газрын шимт хөрсний ялзмагийн хэмжээ тэр хэмжээгээр нэмэгдэх сайн талтай юм. Харин шимт хөрсийг стандартын дагуу суурь судалгаанд үндэслэн хуулаагүй үед сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.
3	Өрөмдлөг, тэсэлгээ	Өрөмдлөг, тэсэлгээ хийх газар болон түүний ойр орчмын шимт хөрс нөлөөлөлд өртөнө.
4	Ухаж ачих	Ухаж ачих үеийн тоосжилт нь шимт хөрсний шимт байдалд нөлөөлнө.
5	Тээвэрлэлт	Тээвэрлэлтийн үеийн шороон замд шууд, шороон замаас үүсэх тоосжилтоор дам нөлөөлөлд орно.
6	Овоолох	Овоолгон доор шимт хөрс дарагдана.

Хүснэгт 12. Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт	Үүсэх тоосонцор нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болно. Мөн хөрс хуулах үед техник тоног төхөөрөмжтэй харьцах аюулгүй ажиллагааны дүрэм зөрчихтэй холбоотой гэмтэх тохиолдол гарч болно.
2	Өрөмдлөг, тэсэлгээ	Нөлөөлөл үзүүлэхгүй
3	Ухаж ачих	Үүсэх тоосонцор нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болно.
4	Тээвэрлэлт	Тээвэрлэлтийн үед үүсэх тоосонцор нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.
5	Овоолох	Үүсэх тоосонцор нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болно.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, БОННҮнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Мөн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага, зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгасан байх шаардлагатай.

Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааныхаа зардалд багтаан төлөвлөж зарцуулах.

Иймд “Фриендшип ресурсис” ХХК нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах зорилгын хүрээнд 2024 оны БОМТөлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах зорилготой.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө

Хүснэгт 13. Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.	Ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөс ялгарах хорт хий орчныг бохирдуулах	Уурхайн бүх түрээсийн автотээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгслийн агаарт гаргах хаягдалд ноогдуулах төлбөрийг төлөх	а/т болон ө/я хэрэгсэл	ҮА-ны төлөвлөгөөнд тусгах	Жил бүр	Агаарын бохирдын төлбөрийн тухай хуулийн 5.4 зүйл
2	Хатуу хучилтгүй зам дээрх тээврийн хөдөлгөөн, бүтээгдэхүүн тээвэрлэж буй машинаас тоосжилт үүсэх	Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг дулааны улиралд услах, чийглэх замыг дагтаршуулах	Шороон замууд	Тоосжилт үүсэх нөхцөлд /үйл ажиллагааны зардалд багтана/	Жил бүр	Агаарын тухай хууль, 9, 11, 23-р зүйл MNS4585:2007
		Тээвэр хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээг нэмж байршуулах, засч тордох		300.0	2024 онд	
3	Гадна тээврийн үйл ажиллагааны явцад салаа зам үүсч шороо тоос ихээр босох	Гадна тээврийн замыг бусад уурхайтай хамтран засч сайжруулах	Төслийн талбайгаас Олон-Овоо өртөө хүртэлх	5,000.0 (уурхайн үйл ажиллагааны зардалд багтана)		
Нийт				300.0.0		

4.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө

Хүснэгт 14. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох	Ус ашиглах хэсгүүдэд хяналт тавих, ус ашиглалтын бүртгэл хийх	Унд ахуйн хэрэглээ болон зам талбайн усалгаа	-	Жил бүр	Усны тухай хуул: MNS0900:1992 Ундны ус- Ундны усны хяналт, шинжилгээ
2		Уурхайгаас гарч байгаа ахуйн хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авах		-	2024 онд	
3	Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн зэрэг бодис алдагдах, хур тунадас болон үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулах	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах,	Үйл ажиллагааны турш	-	Үйл ажиллагааны туршид	
		ШТС-ын түгээх хэсгийн цардмал талбайн хэмжээг нэмэгдүүлэх асгарсан түлш хөрс, усанд нэвчихээс сэргийлэх	ШТС-н орчимд	1,000.0	2024 онд	
		Ус сорох насос болон үүсгүүрийн шатах болох тослох материал зумфны усанд алдагдахаас сэргийлсэн зөөврийн суурийг сайжруулах, ашиглалтын нэмэгдүүлэх	Уурхайн ёроод ухсан ус цуглуулах зумфны орчим,	200.0	2024 онд	
		Нийт		1,200.0		

4.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн хамгаалал хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүснэгт 15. Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн хамгаалал хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс бохирдуулах	Автомашин тос масло асгарч бохирдсон хөрсийг хуулан авч тусгаарлагч гадаргуу дээр овоолон 18-20%-ийн хлораминий уусмалаар бороожуулан ариутгаж, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07мг/кг-аас ихгүй, 4 этилт хар тугалганы хэмжээ 0.05 мг/кгаас ихгүй нөхцөлд буцаан байршуулах	Төслийн талбайд	50.0	ҮА-ны туршид	Монгол улсын засгийн газрын 1995 оны 143-р тогтоолын 2-р хавсралт “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам” эзэмшил газрынхаа төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх, MNS3297-1991 “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”, MNS4919-2000 “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”, MNS4920-2000 “Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага, хэмжээ”
2	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдох	Шатах тослох материалын агуулах №1-ийн хашааг шинчлэн дээвэрлэж хурын усаар зөөгдөн хөрс бохирдуулахаас сэргийлэх	Шатах тослох материалын агуулах	1,000.0	2024 онд	
3	Уурхайн гал тогоо, угаалгаас гарах шингэн хаягдал, мөн хоолны үлдэгдэл, хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр хөрс бохирдох	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаяж байх	Хог хаягдлын МТ-нд тусгагдсан	300.0	ҮА-ны туршид	
		Ахуйн гаралтай шингэн доторлогоотой нүхэн цооногийн арчилгааг байнга хийж байх, бүрэн бүтэн байдалд хяналт тавих	Хог хаягдлын МТ-нд тусгагдсан	-	ҮА-ны туршид	
		Ажилчдын доод кемпэд хөрсөнд нэвчдэггүй, соруулдаг 00- шинээр байгуулах.				
Нийт				1,350.0		

4.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Техникийн болон биологийн нөхөн сэргээлт

2024 онд уурхайн ашиглалтын явцад биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй ба олборлолтоос гарах шимт хөрсийг услан ургамал ургалтын нөхцөлийг дэмжих ажлыг 1.56 га талбайн хэмжээнд гүйцэтгэнэ. Шинээр хуулсан шимт хөрсийг засч тэглэн арчлах, үржил шимийг сайжруулах зорилгоор олон наст ургамал тарихаар төлөвлөж байна. Мөн намар модны ургалтын байдалд үнэлэлт өгөн нөхөн тарилтыг хийнэ.

Хүснэгт 16. Нөхөн сэргээлтийн зардал

Үзүүлэлт	Гүйцэтгэх ажил	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгж зардал мян.төг	Зардал мян.төг	
1	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсийг арчилах хамгаалах / 1.56 га /	Шимт хөрсийг услах	1,000.0	1,000.0
			Олон наст ургамал тарьх	1,810.0	1,810.0
		Тэрбум модны хүрээнд мод тарих	Нөхөн тарилт 300 ш	4.0	1,200.0
			Мод бордох	750.0	750.0
			Мод тээвэрлэлт	200.0	200.0
2	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолго үүсгэх / 3.7 га талбайд шинээр /	5,074,000.0 /ҮА зардалд орно/	Үйл ажиллагааны зардал	
Нийт				4,960.0	

4.5. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 3.1.11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг дараах хүснэгтэнд тодорхойлсон болно.

2024 онд хийх дүйцүүлэх хамгаалах ажлын чиглэл, саналыг авахаар суманд албан бичиг өгсөн бөгөөд одоогоор хариу ирээгүй байна. Урьд жилүүдийн жишгийн дагуу 0.5 га газарт (2022 онд ажил хийсэн газарт талбай үлдсэн, 2023 оны газар бүрэн нөхөн сэргээгдсэн) дүйцүүлэн хамгаалах ажилд 4.0 сая.төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 17. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Нөхөн сэргээлт хийх	Нөхөн сэргээлт хийх газарт шаардлагатай нөхөн сэргээлт, тэмдэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.	Даланжаргалан сумаас гаргасан саналаар	4,000.0	-
Нийт			4,000.0	

4.6. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон “Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна. 2024 онд тус төслийн үйл ажиллагаатай холбоотой нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээ хийгдэхгүй болно.

4.7. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна. Энэ төлөвлөгөөнд үйлдвэрлэл дэд бүтцийн байгууламжийг барьж байгуулах, ашиглах болон үйл ажиллагааны явцад илэрсэн түүх, соёлын өвийг хэрхэн хамгаалах арга хэмжээ авах талаар тусгана.

2024 онд соёлын биет өвийг хамгаалах ажлын чиглэлээр санал авах суманд хандсан бөгөөд одоогоор хариу ирээгүй байна. 2023 онд түүхийн өвийг хамгаалах чиглэлээр тус сумын Бичигт багийн Хөшөөтийн ухаа нэртэй газарт байрлах Хөшөө, Их нартын байгалийн нөөц газрын Монголын хад нэртэй газарт байрлах Тахилын байгууламжийн хамгаалалтын хашаа хийсэн.

Хүснэгт 18. Төслийн явцад хэрэгжүүлэх түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Дорноговь аймгийн Даланжаргалан сум	Түүх, соёлын өв дурсгалуудын талаарх мэдээлэлд анхааралтай хандах, сэргээх ажилд оролцох	Их нартын цогцолбор газарт ажиллаж байгаа байгаль хамгаалагчдын дулаан ажлын байртай нөхцөлийг бүрдүүлэх	5 тн нүүрс буюу 500.0	2024 онд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
		Сумтай хамтран соёлын биет өвийг хамгаалах ажлыг хийнэ.	1,000.0	2024 онд	
	Нутгийн иргэдийн уламжлалт амьдралын хэв маяг, тахилга шүтлэгт хүндэтгэлтэй хандах, дэмжлэг үзүүлэх	Санхүүжүүлэх	500.0	2024 онд	-
Нийт			2,000.0		

4.8. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

Хүснэгт 19. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр					
1.	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс уурхайн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Дорноговь аймгийн Даланжаргалан	-	Ус цаг уур, орчны хяналт Шинжилгээний тухай хууль, 15-р зүйл MNS 4585:2007
2.	Гал түймрийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Галын хорны хүргээмжыг нэмэгдүүлэх, галын мэдээлэх хэрэгсэлийн ашиглалт, бэлэн байдалд хянат тавих	Төслийн хэмжээнд	500.0	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS 5566:2005 MNS 0640:89 MNS 639:89
3.	Газар хөдлөлт, чичирхийллийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн хэмжээнд	-	Гамшигаас хамгаалах тухай, 27-р зүйл
Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр					
4.	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох,	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн хэмжээнд	ҮА-ны төлөвлөгөөнд тусгах 1,000.0	MNS 4990:2000
		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх			MNS 4969:2000
		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах		ҮА-ны төлөвлөгөөнд тусгах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 15-р зүйл
Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ					
5.	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэл	Салхи ихтэй, тоосжилт үүсэх улиралд тоосжилтыг бууруулах арга хэмжээг тогтмол авах	Төслийн хэмжээнд	орчны хяналт шинжилгээнд зардал нь суусан	MNS5885:2008 MNS6148:2010
		Орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээ үр дүнг магадлан итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораториор баталгаажуулах			
		Шимт хөрсний овоолгын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж байх.	Уурхайн шимт хөрсний овоолго	ҮА-ны төлөвлөгөөнд тусгах	
Нийт				1,300.0	

4.9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 20. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн Өртөг /мян.төг/	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хөрс, ус, агаарын бохирдол үүсгэх	Хог хаягдлыг нэг цэгт цуглуулан ангилж, битүү саванд хадгалан тогтмол хугацаанд тээвэрлэж байх	Төсөл хэрэгжих орчин	300.0	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд MNS 5850:2008 MNS ISO11074-1:2001 Олон улсын стандартын дагуу, Засгийн газрын 2002 оны 135 дугаар тогтоолын хавсралт Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, Савлах, түр байршуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устгах журам Хог хаягдлын тухай хууль, 2017 он Нүхэн жорлон, угаадасны нүх, Техникийн шаардлага MNS 5924:2015
	Хөрсийг тос тосолгооны материалаар бохирдуулахыг хориглох, бохирдсон хөрсийг эрүүлжүүлэн хөрсний овоолгод шилжүүлэх	Төслийн талбай	ҮА-ны зардал	Жил бүр	
	Засварыг цардмал талбайд хийж тос хөрсөнд асгарахаас сэргийлэх. Цардмал талбайд будган тэмдэглээ хийж ашиглалтыг сайжруулах	Төсөл хэрэгжих орчин	200.0	2024 он	
	Бүх төрлийн дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилан холбогдох байгууллагуудад тушаах	Төсөл хэрэгжүүлэгч	100.0	Жил бүр	
	Хаягдал хөдөлгүүрийн тос, бусад тосолгооны материалын хаягдал болон дугуй аккумулятор зэргийг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хүлээлгэж өгөх	Үйл ажиллагааны турш	350.0	Жил бүр	
	Хаягдал тосны шүүр тунгаах сав байршуулах		150.0	2024 он	
	Энгийн хаягдал, арчих материал, тосны шүүр гэсэн ангилал бүхий хогийн сав хийж байршуулах		1,000.0	2024 он	
Физик нөлөөллийг бууруулах чиглэлээр					
Үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин механизмын, хөдөлгүүрээс үүдэлтэй шуугиан ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.	Техник тоног төхөөрөмжийн шуугианы хэмжээг тодорхойлуулах	Төслийн талбай	50.0	Жилд 2 удаа	MNS 5003:2000
	Дуу шуугиан ихтэй ажлын байранд ажиллагсдыг сонсголын эрхтэн хамгаалах хэрэгслээр хангах	Шуугианы түвшин өндөр хэсгүүд	ҮА-ны зардал	Жил бүр	
Нийт			2,150.0		

4.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 3.1 дүгээр зүйл, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд зааснаар төслийг хэрэгжүүлэх явцад төслөөс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) гэнэ.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр нь “Далангийн нүүрсний ордыг ил аргаар олборлох” төсөл хэрэгжиж буй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх мөн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ нь байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Уг хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжих газрын агаар, усны чанар, хөрс, амьтан, ургамлын асуудлыг онцлон анхааран авч үзсэн бөгөөд байгаль орчны бохирдол, өөрчлөлтийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол улсын хууль тогтоомж, стандарт, дүрэм, заавар арга зүйг баримтлах шаардлагатай.

Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

Хяналт хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал	Дээд доод хязгаар
Агаарын чанар, бохирдлын мониторинг							
Тоос: PM2.5, PM10, Нийт тоос Утааны хий: Хүхэрлэг хий, Азотын давхар исэл, Угаарын хий	Нүүрсний агуулахын талбайгаас салхины чигийн дагуу 200 м-т	Жилд 2 удаа	Утааны хий, тоос	40.0	240.0	MNS 0017-2-5-12:1988 MNS ISO 4221: 2002 MNS0012-1-003:1982 MNS 0017-2-5-11:1988 MNS 4048:1988 ISO 16017-1:2000 ISO 16362-2:2003 MNS 5365:2004	24 цагийн дундаж: Нийт тоос-150 мкг/м ³ PM2.5-50 мкг/м ³ PM10-100 мкг/м ³ SO ₂ -20 мкг/м ³ NO ₂ -40 мкг/м ³ CO-30000 мкг/м ³
	Ажилчдын кемпийн ойролцоо			40.0			
	Ил уурхай, хөрсний овоолгын ойролцоо			40.0			
Дүн /мян.төг/					240.0		
Усны нөөц, чанар, бохирдлын мониторинг							
Химийн ерөнхий шинжилгээний	Ундны ус авч хэрэглэж буй уст цэг, бохир ус, шүүрлийн ус	Улиралд 1 удаа	3 дээж	50.0	600.0	MNS6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Газрын доорхи ус: pH-6.5 – 8.5 NH ₄ - 3.0 мгN/л NO ₂ – 1 мг/л NO ₃ - 50 мг/л PO ₄ – 3.5 мг/л Cl – 350 мг/л F – 1.5 мг/л SO ₄ -500 мг/л Mn-0.1 мг/л Ag-0.1 мг/л Fe-0.3 мг/л
Дүн /мян.төг/					600.0		

Хөрсний чанар, бохирдлын мониторинг							
Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO ₃), хөдөлгөөнт кали (K ₂ O), хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), Шингээгдсэн сууриуд Ca, Mg Хар тунгалаг (Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As)	Овоолго шорооноос 200 м-т	Жилд 2 удаа	Ерөнхий, хүнд металл	100.0	800.0	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Pb-100 мг/кг Cd-3 мг/кг As-6 мг/кг Cu-100 мг/кг Zn-300 мг/кг
	Цэвэр хөрс			100.0			
	Ажилчдын кемпийн ойролцоо			100.0			
	Хог хаягдлын цэгийн хажууд			100.0			
Дүн /мян.төг/				800.0			
Нийт /мян.төг/				1,640.0			

4.11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 22. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ				
Удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	Үйл ажиллагааны турш	Жил бүр	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм,	
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа бүх ажилчдад зохион байгуулах, харьяалах багийнхаа байгаль орчны ажилтантай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны турш	-	ISO 14001:2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо	
Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	2025 онд хийлгэх	-		
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэх	2027 онд хийлгэх			
Орон нутгийн иргэдийн санал болох сумын багийн төвийн цаашдын хөгжилд туслалцаа үзүүлэх	Үйл ажиллагааны турш /2024 онд багийн иргэд, малчдад зориулан гүний худаг гаргах/	Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажлын зардал		
НИЙТ ДҮН		0.0		

4.12. БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 23. БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Иргэд олон нийт/дурын оролцогч, сонирхогч талууд	Санал, хүсэлт хүлээн авах төсөлтэй холбогдох гомдлын барагдуулах	Байгаль орчны талаар тавьсан санал гомдолтой холбогдол бүхий бүх төрлийн мэдээлэл	Төсөл хэрэгжих бүх хугацааны турш	Сонирхогч оролцогч талуудыг хүссэн мэдээллээр хангах	“Фриендшип ресурсис” ХХК
Сумын байгаль орчны ажилтан	Жилийн төлөвлөгөөг батлагдсан дариуд, биелэлтийн тайланг хэлэлцүүлэхээс өмнө хүргүүлж танилцуулга хийх ба санал авах	Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Жилийн эхэн болон эцэст 1 удаа		“Фриендшип ресурсис” ХХК
Багийн ИНХ	Жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах		Жилийн эцсээр 1 удаа		“Фриендшип ресурсис” ХХК
БОАЖЯ	Тухайн жилийн тайланг боловсруулан хүргүүлж дараагийн жилийн төлөвлөгөөнд санал авч төлөвлөгөөг батлуулна.	Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Жилийн эцэст 1 удаа	БОМТ түүний хэрэгжилт	“Фриендшип ресурсис” ХХК

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй “Далангийн нүүрсний ордыг ил аргаар олборлох” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2024 онд хийгдэх ажлын нийт зардал нь **18 900.0 мян.төг** болж байна.

Хүснэгт 24. БОМТ-ний нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Нийт зардал (мян.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,850.0
		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	4,96.0
		Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	4,000.0
		Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	0.0
		Түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	2,000.0
		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,300.0
		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,150.0
2	Удирдлага зохион байгуулалтын зардал		0.0
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,640.0
Нийт зардал			18 900.0